МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.10.01 № 20

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАНАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

Шинэ хилийн боомт нээх талаар

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр иргэдтэй хийсэн уулзалт дээр Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг Цагаан дэл уулаар шинэ боомт нээх үйл ажиллагааг түдгэлзүүлсэн шийдвэр гаргасан байдаг. Гэтэл боомтын бүтээн байгуулалтын үйл ажиллагаа одоог хүртэл явагдсаар байна. Үүний улмаас нутгийн иргэд болон үйл ажиллагаа явуулахаар ирж буй компанийн хүмүүсийн хооронд үл ойлголцол гарч, таагүй нөхцөл байдал үүсэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1. Боомт нээх үйл ажиллагааг түдгэлзүүлэх тухай Ерөнхий сайдын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар Засгийн Газраас ямар арга хэмжээ авсан талаар мэдээлэл;

2. Боомт нээх үйл ажиллагааг түдгэлзүүлэх тухай Ерөнхий сайдын шийдвэр гарснаас хойш энэ хэсгээр удаа дараа түр хил нээн, барилгын материал оруулж ирсэн, бетон суурьтай маш их хэмжээний төмөр хашаа барьж Хятад ханзаар пайзжуулан, Монгол, Хятад нийлсэн олон хүн хил дээр ажиллаж, Монгол Улсын хилийн дархан байдал алдагдаж байна. Ерөнхий сайдын түдгэлзүүлсэн шийдвэр цуцлагдаагүй байхад ямар байгууллагын, ямар албан тушаалтны зөвшөөрлөөр ямар компани энэ боомтын үйл ажиллагааг явуулж буй талаар тодорхой мэдээлэл;

3. Боомттой холбоотой 270 км концессын гэрээтэй авто замын ажлын явц ямар шатанд яваа, цаашид үргэлжлэх, эсэх талаар болон концесс задарсан тул дахин концессын гэрээ байгуулах албан бус мэдээлэл байгаа тул үүний талаар тодруулга, мэдээлэл зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Г.ГАНБААТАР

2024000040